

**АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН
ҮЗҮҮЛЭЛТИЙН 2022 ОНЫ БИЕЛЭЛТ**

2023 оны 02 сарын 16-ны өдөр

Эрдэнэбулган сум

Аймгийн нэр: Архангай

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь	Тайлбар
			2020 он	2021 он	2021 он	2022 он	2022 он		
	1	2	3	4	5	6	7	8	9
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ									
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн	Сая төгрөг	556790.0	573493.7	-	590698.5	-	-	СҮХорооны статистикийн эмхтгэл 6,7 сард гарна.
2	Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	Сая төгрөг	5.9	5.97	-	6.01	-	-	СҮХорооны статистикийн эмхтгэл 6,7 сард гарна.
3	Төсвийн орлого	Сая төгрөг	8472,3	9685,0	15189.9	10654,0	15390.5	144.4%	
4	Төсвийн зардал	Сая төгрөг	76896,5	75705,1	81786.1	78651,4	52992.5	148.4%	Аймгийн 2022 оны орон төсвийн зардал
5	Төсвийн тэнцэл		68424,2	66020,1	66596,2	67997,4	37608.8	180.8%	
6	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	Хувь	90.%	100%	80%	100%	82%	82%	

7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь	Хувь	80.0%	80.0%	79%	82.0%	93.8%	114%	
8	Ажилгүйдлийн түвшин	Хувь	5.2	5.2	4.3	5.1	4.8	94.1%	
9	Ажиллах хүчний оролцооны хувь	Хувь	67.9%	68.0%	70.3%	69.0%	77,5%	112%	
10	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	Хувь	76.3%	77.5%	87.8%	78.5%	75.9%	96.6%	
11	/Эдийн засгийн идэвхтэй хүн ам ажиллах хүч/-ний нийгмийн даатгалд эзлэх хувь	Хувь	33.2%	33.5%	35.9%	33.7%	37.3%	110%	
12	Шинээр бий болгосон ажлын байрны тоо	Тоо	1120	1250	1184	1300	1062	81.6%	
13	Хэрэглээний үнийн индекс	индекс	100.3		110.8				СҮХорооны статистикийн эмхтгэл 6,7 сард гарна.
14	Малын тоо	Мянган толгой	6201.9	6293.4	5562.2	6348.6	5886.0	92.7%	
15	Хураан авсан үр тариа	Мянган тонн	4916	7000	13349	9000	9987	110%	
16	Хураан авсан малын тэжээл бусад	Мянган тонн	7578	7700	10665.5	7800	4355	55.8%	
17	Хураан авсан хүнсний	Мянган	1150	1200	1163.9	1250	2599	207%	1631 тн төмс, 968

	ногоо бусад	тонн							тн хүнсний ногоо
18	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	тоо	124	124	-	8000	7173	89.6%	
19	Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Тоо	712	745	849	780	808	103%	
20	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь	хувь	7.27%	7.82%	7.66%	8.56%	8.33%	97.3%	
21	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	97%	97.5%	97.5%	98%	98%	100%	
Хэсгийн дундаж: 112%									
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ									
22	Хүн амын дундаж наслалт	тоо	71.76	71.85	-	71.81		-	СҮХорооны статистикийн эмхтгэл 6,7 сард гарна.
23	Хүний хөгжлийн индекс	индекс	0.672	0.672	-	0.672		-	СҮХорооны статистикийн эмхтгэл 6,7 сард гарна.
24	Жендерийн тэгш бус байдлын индекс	индекс	0.802	0.802	-	0.801			СҮХорооны статистикийн эмхтгэл 6,7 сард гарна.
25	Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	437	435	412	430	524	0%	Өмнөх онуудад Ковид-19 цар

									тахалаас үүдэлтэй хөл хорио тогтоож гэмт хэргийн гаралт бага байсан бол 2022 онд гэмт хэргийн гаралт огцом өссөн байна.
26	Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин	хувь	47.4%	49%	56.3%	50.2%	56.6%	112%	
27	PM2.5 тоосонцорын жилийн дундаж агууламж	М кг/м ³	-	-	-	-	-	-	
28	PM10 тоосонцорын жилийн дундаж агууламж	М кг/м ³	-	-	-	-	-	-	
29	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	хувь	19.4%	19.8%	19.5%	20.3%	20.3%	100%	
30	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	0.12%	0.15%	0.18%	0.20%	0.20%	100%	
31	Хот суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	хувь	0.75%	0.80%	0.85%	0.85%	0.85%	100%	
32	100.000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин	Промиль	133.8	0	243.6	0	0	100%	
33	1.000 амьд төрөлтөд ногдох нялхсын	Промиль	14.1	14	9.7		13.4	97.1%	

	эндэгдлийн түвшин					13.8			
34	10.000 хүн амд вируст гепатитын өвчлөл	тоо	0.6	0.6	0.4	0.6	0.3	50%	
35	Тухайн жилийн товлотт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	хувь	98.4	98.5	98.1%	98.6%	98.2%	99.5%	
36	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	62.7%	65.0%	53.9%	67.0%	41.0%	61.1%	
37	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хувь	хувь	57.3%	60.0%	48.6%	62.0%	38.3%	61.7%	
38	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	56.4%	59.0%	63.4%	60.0%	57.4%	95.6%	
39	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	88.8%	89.0%	93,5 %	89.5%	91.0%	101.6%	
40	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	90.7%	90.7%	92,8 %	90.8%	93.1%	102.5%	
41	Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	30.2	30	23.9	29.5	29.4	99.6%	
42	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	27.8	27.5	28.6	27.3	29.0	94.1%	
43	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж	тоо	500.0	502.0	521	504.0	512.7	101.7%	

44	Оюутан цэрэг сургалтад хамрагдах суралцагчдын тоо	тоо	9	10	-	10	-	-	Төсвийн хэмнэлтийн хууль хэрэгжсэнтэй холбоотойгоор бүх аймгийн хэмжээнд хэрэгжээгүй болно.
45	Төрийн цахим үйлчилгээний тоо	тоо	54	121	65	181	335	185%	
Хэсгийн дундаж: 96.8%									
Нийт дундаж: 104%									

1.ТӨСӨВ

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 2022 онд аймгийн төсөвт 15.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 18.2 тэрбум төгрөгийг орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 115.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

2. САНГИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ

Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 2022 оны жилийн эцсийн байдлаар 82 хувьтай байгаа бол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлт 93.8 хувьтай байна.

3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Архангай аймгийн ажилгүйдлийн түвшин хүн ам орон сууцны 2022 оны улсын ээлжит тооллогын дүнгээр 4.8 хувьтай байна.

Төрийн болон хувийн хэвшлийн салбарт 2022 онд 1062 ажлын байр шинээр бий болсон байна. *Эдийн засгийн салбараар нь авч үзвэл:* 174 иргэн боловсруулах үйлдвэрт, 210 иргэн хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, 416 иргэн төрийн удирдлага батлан хамгаалах албан журмын шаардлагаар, 69 иргэн барилга, 85 иргэн худалдаа, гэр ахуй засвар үйлчилгээ, 32 иргэн боловсролын салбар, 14 иргэн эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбар, 62 иргэн бусад эдийн засгийн үйл ажиллагааны салбарт тус тус ажилд орсон байна.

4. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

2022 оны 12 сарын байдлаар бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 113.6 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны 11 дүгээр сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 314 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 51 /16.2%/, 263 /83.8%/ хувийн нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байлаа. Тухайлбал хэрчсэн гурил, алим, гадил, төмс, манжин, сонгино, байцай, үзэм, масло, зайдас, өндөг, үхрийн мах, хонины мах, адууны мах, тахианы мах, хатуу чихэр, ариуцн цэврийн цаас зэрэг барааны үнэ 0.1-21.4 хувиар өссөн байна. Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 3.5 хувь буюу 11 нэрийн бараа үйлчилгээний үнэ буурч, 68.5 хувь буюу 215 нэр төрлийн бараа үйлчилгээний үнэ тариф өссөн бол, 88 нэр төрлийн 28 хувийн бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

5. МАЛ АЖ АХУЙ

Аймгийн дүнгээр 2022 оны эцэст урьдчилсан байдлаар 5.9 сая толгой мал тоологдож өмнөх оноос 324 мянга буюу 5.8 хувиар өссөн байна. төрлөөр нь авч үзвэл: 1.7 мянга нь тэмээ, 468.0 мянга нь адуу, 814.5 мянга нь үхэр, 3.1 сая нь хонь, 1.5 сая нь ямаа эзэлж байна. Өнгөрсөн оныхоос нийт малын тоо 324 мянган толгойгоор өссөнөөс хонь 48 хувиар буюу 139.9 мянган толгойгоор, ямаа 2.7 хувиар буюу 39.9 мянган толгойгоор, тэмээ 3.1 хувиар буюу 52 мянган толгойгоор, адуу 12.4 хувиар буюу 51.6 мянга, үхэр 12.8 хувиар буюу 92.4 мянгаар төрөл тус бүр дээр тус тус өссөн байна.

6. ГАЗАР ТАРИАЛАН

2022 онд 11668 га-д үр тариа, 260 га-д төмс, 120 га-д хүнсний ногоо, 3603 га-д малын тэжээлийн ургамал, 1225 га-д техникийн ургамал тус тус тариаллаа. Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд үр тариа 12.7 хувиар, техникийн ургамал 2.9 дахин нэмэгдсэн бол, тэжээлийн ургамал 17.9%, төмс 16.7%, хүнсний ногоо 21.4% хувиар тус тус буурсан байна.

7. ГЭМТ ХЭРЭГ

2022 онд аймгийн хэмжээнд 467 хүн гэмт хэрэгт холбогдож 524 гэмт хэрэг гарсны дотор хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 147, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 241, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 25, хүрээлэн бу орчны эсрэг гэмт хэрэг 74, бусад 37 гэмт хэрэг тус тус гарсан байна. Гэмт хэргийн улмаас 19 хүн нас барж, 178 хүн гэмтэж бэртэн улс орон иргэдэд 1518.5 сая төгрөгийн хохирол учирсан байна. Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин 56.6 хувьтай байна.

8. ЭРҮҮЛ МЭНД

2022 онд аймгийн хэмжээнд эхийн эндэгдэл гараагүй. Нялхасын эндэгдэл 18 гарч 1000 амьд төрөлтөнд харьцуулсан түвшин нь 13 ногдож байна. Халдварт өвчний тохиолдол 5683 гарч, 10000 хүн амд харьцуулахад 593 байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсөдийн 91.7 хувь нь коронавируст халдварт өвчнөөр, 5.2 хувь нь бэлгийн

замын халдварт өвчнөөр, 3.1 хувь нь бусад халдварт өвнөөр өвчилсөн байна. Халдварт өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.3 дахин буурсан үзүүлэлттэй байна.

9. БОЛОВСРОЛ

2022-2023 оны хичээлийн жилд аймгийн ерөнхий боловсролын 30 сургуулийн 688 бүлэгт 19461 сурагч өдрийн ангид суралцаж, орой, эчнээгээр суралцагч байхгүй, дүйцсэн хөтөлбөрөөр 219, нийтдээ эдгээр сургалтын хэлбэрээр 19680 хүүхэд суралцаж байна. Суурь боловсролын хамран сургалт 92,7 хувь, бага боловсролын хамран сургалт 92 хувь, аймгийн хэмжээнд 35 цэцэрлэгийн 230 бүлэгт 7224 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна. Үндсэн сургалтад 5650 хүүхэд, хувилбарт сургалтад 1574 хүүхэд хамрагдаж байна. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь 91%, үндсэн бүлгийн хамран сургалтын хувь 67,5 хувь, 5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалтын хувь 94,7 % байна.

Багш нарын ажлын гүйцэтгэлийг сурагчдын сурлагын ахицаар үнэлэх үнэлгээнд төрийн өмчийн 30 сургуулийн 1022 багш, 19.0 мянга орчим сурагчид, тэдний эцэг эхчүүд, сургуулийн удирдлагууд хамрагдсанаас улсын хэмжээнд эхний 3-т дүгнэгдсэн. 2021-2022 оны хичээлийн жилд Элсэлтийн ерөнхий шалгалтад Архангай аймаг 512,7 хувийн дундаж үнэлгээтэйгээр шалгагдсан. ЭЕШ-ын 10 хичээлээс 5 хичээлийн дундаж өмнөх оноос 0,2-7 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС